

## Соёлын төвн танилцуулга

Одоогийн Соёлын төв нь 9 орон тоотой . Эрхлэгч 1, хөгжмийн багш 1, бүжгийн багш 1, өвийн ажилтан 1, номын санч мэдээллийн ажилтан 1, үйлчлэгч 1, галч манаач 3 бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна. Соёлын төвийн боловсон хүчний үзүүлэлт дээд боловсрол 3, тусгай дунд боловсрол 1, бүрэн дунд боловсрол 4 байна. Үүнээс:



Эрхлэгч: “МУ-ын тэргүүний ардын авьяастан” Монголын үндэсний дууны их наадмын шилдэг оролцогч Л.Алтанхуяг нь 8 жил Соёлын байгууллагад ажиллаж байна. Хөгжмийн багш: МУСТА. П.Даваадорж нь 26 жил соёлын байгууллагад ажилласан зэрэг байгууллагын шилдэг ажилтан, албан

хаагчид ажиллаж байна. Манай байгууллагын хамт олон нь архив бичиг хэргийн бүрдүүлэлтийг хийж сан хөмрөг үүсгэн, тэмдэглэлт баяр ёслол аливаа соёлын арга хэмжээг удирдамж хөтөлбөрийн дагуу зохион байгуулалтын өндөр түвшинд хийж гүйцэтгэн, байгууллагын өнгө үзэмж, эмх цэгц, өрөө тасалгааны тохижилтыг анхаарч үйлчлүүлэгчдэд таатай, соёлч үйлчилгээг эрхэмлэн ажиллаж ирлээ. Соёл олон



нийтийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж баг, байгууллагын уялдаа холбоотой ажлуудыг хийж гүйцэтгэн иргэдийн хүсэл сонирхолыг харгалзан судалгаа хийж чанартай төрийн үйлчилгээг хүргэх зорилгоор амралтын өдөр, илүү цагийг ажлын цагтай уялдуулан зохицуулж үйл ажиллагаагаа явуулж байна. Төрийн алба түүний ёс зүйн дүрэм журмын дагуу, улс төр ба аль нэг намын нөлөөллөөс ангид, үзэл бодолд

туйлшралгүй уян хатан байж тухайн ажлын байрны тодорхойлолтонд заагдсан эрх

үүргийн дагуу удирдах, гүйцэтгэх, туслах үйлчилгээний ажил албан тушаалыг тогтвор суурьшилтайгаар биелүүлэн ажиллаж байна. Соёл олон нийтийн үйлчилгээг иргэдэд



хүртээмжтэй хүргэх зорилгоор багийн иргэдийн дунд өдөрлөгийг улиралд зохион байгуулах, явуулын иж бүрэн соёлын үйлчилгээг жил бүр тогтмол үзүүлэх ажлыг төлөвлөн ажиллаж байна. Соёл олон нийтийн үйл

ажиллагааны түвшинг тодорхойлох, иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа, өнөөгийн нийгмийн хүсэл сонирхол зэргийг иргэдийн дунд санал хүсэлтийн хуудас, дэвтэр, нууц хайрцаг зэргийг аялуулан дүгнэлт хийж, асуудлыг тодорхойлон хариуцлага, чанарыг сайжруулах арга замыг эрэлхийлэн ажиллаж байна. Байгууллагын ажилчдыг сар бүрийн нэг шинэлэг ажлыг санаачилан хийж ажлын төлөвлөгөөнд тусгуулан гүйцэтгэлийг тооцож, долоо хоног бүрийн нэг өдрийг өөрсдийн өдөр болгон боловсрол, ур чадвараа дээшлүүлэх, чөлөөт цагаа өнгөрүүлэх, сургалт сурталчилгаа хийх өдөр болгон зааж өгсөн. Мөн ажилтан албан хаагчдын сурч боловсрох боломжийг нь нээлттэй байлгаж ,мэргэжил дээшлүүлэх сургалтанд байнга хамруулж байна. Байгууллагын үйл ажиллагаа, хөтөлбөрт арга хэмжээ, цаг үетэй холбоотой асуудлуудыг сумын удирдлага, тэргүүлэгчид хамт олны хурлаар авч хэлэлцэн шат дараатай



хэрэгжүүлэх ажлыг шаардлагын хэмжээнд үүрэг болгон төрийн албаны стандартын дагуу мөрдөж ажиллаж сумандаа “**2015 оны шилдэг төрийн байгууллага**”-аар өргөмжлөгдөн ажиллаж байна.



Баг байгууллага иргэдийн дунд “Дэлгэр зун” урлаг спортын наадам, “Мөнгөн өвөл” урлагийн наадмуудыг жил бүр зохион байгуулдаг уламжлал болгон тогтоон ажиллаж байна. Байгууллага хамт олон нь Соёлын тухай хуулийн 5.18.3 – т заасан хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах өвөл цагийн соёл хүмүүжлийн ажлын нээлтийн арга хэмжээ, соёлын ажилтны өдрөөр Соёлын төв нь дангаар бие даасан ажилтан, албан хаагч нарын бие

бүрэлдэхүүнтэй урлагийн тоглолтыг өөрийн тайзнаа найруулан тоглож үзүүлдэг чадвартай хамт олныг төрүүлсэн. Тус сумын нийтийн номын сан нь Мон biblo программдаа бүх номоо шивж оруулан улиралд 514 уншигчдад 945 номыг гэрээр болон зөөврөөр, уншлагийн танхимаар олгон үйл ажиллагаагаа тогтмол явуулж мөн номын сангийн мэдээллийн самбар, үзүүлэнгүүдийг шинэчлэх ажлын байраа тохьжуулах ажил хийгдэж байна. Номын сангийн үйл ажиллагааны Монбиблио праграммд номын сангийн фондод байгаа бүх номыг 100% оруулж дуусгасан. | Бар кодыг хэвлэж ном тус бүрт наах, уншигч болон ном олголтыг тус программд оруулж нэвтрүүлсэн байна. Соёлын төвийн дэргэд орон тооны бус соёлын зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй сонгож Сумын Засаг Даргын албан тоотоор батлуулж ажиллах журмыг гаргаж хурлаар батламжлав. Соёлын өвийг хамгаалах, угийн бичиг хөтлөх ажлын чиглэлээр суманд ажлын хэсгийг ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар батлуулж шаардлагатай хамгаалах түүх соёлын дурсгалын газруудыг бүртгэлжүүлж газар дээр баримтжуулах, угийн бичиг хөтлөх сургалтыг зохион байгуулж өрх бүрийг хамруулах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Нутгийн онцлог болсон буриад урианхай үндэстэний хэл соёл, ахуйн болон эдийн соёл болох дээл хувцас, нутгийн ардын дуу, суухан хуур хөгжим, ёохор бүжиг, урианхай биелэгийг уламжлал болгон дэлгэрүүлж

уламжлан авч үлдэх, ахуйн соёлтой ард түмний ёс заншил, өв уламжлал устгах аюулаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Нутаг орны онцлогт тохирсон бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, өвөрмөц ёс заншил, өв соёлтой ард түмний бахархал болсон ардын язгуур урлагийг хөгжүүлэх талаар аймаг бүсийн уралдаан тэмцээнүүдэд идэвхитэй оролцох, залуу хойч үед ардын аман урлаг, язгуур урлаг, аман уламжлалт илэрхийллүүдийг сурталчилан таниулж өвлүүлэх ажлыг зорилгоо болгон ажиллаж байна. Түүх соёлын дурсгалт газар нутгийн судалгааг гаргаж 37 нэр төрлийн байгалийн цогцолборт газар, хөшөө, суварга, хадны бичиг, рашаан, хиргисүүр зэрэг зүйлийг бүртгэлд оруулсан. Орон нутгийн өмчит үнэт дурсгалт зүйлс 3-г бүртгэлд оруулж хувь хүний эзэмшилд хадгалагдаж байна. Соёлын биет бус өвийг тээгч 42 авъяастаныг бүртгэлд оруулаад байна. Түүх соёлын дурсгалт зүйлсийг нээн илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх соёлын өвийн бүртгэл мэдээллийн ажлыг эрчимтэй эхэлж байна. Соёлын биет бус өвийг өвлөн тээгчдийн тоог олшруулах сургалтыг зохион байгуулж, өв соёлоо дээдлэх ухамсартай иргэнийг төрүүлэх танин мэдэхүйн тэмцээн уралдаан тогтмол зохион байгуулах, түүхийн самбар мэдээ мэдээллийг иргэдэд нээлттэй байлгаж, угийн бичиг хөтлөх, өв уламжлалын холбогдолтой домог түүхтэй нутгийн ардын дууг өвлүүлэн заах зэрэг сургалтуудыг зохион байгуулж байна.

Лавлагаа гаргасан:

Соёлын өвийн ажилтан:

С.Далайжаргал